



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/627

Булган сум

С.Бат-Эрдэнэтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 343-346 дугаар зүйл, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аймагт нэн шаардлагатай мэргэжлээр гадаадын их сургуульд суралцах оюутнуудыг Бүгд Найрамдах Солонгос Улсын Хусо Их сургуульд суралцуулахад шаардлагатай шат дараалсан арга хэмжээг зохион байгуулах ажлыг Солонгост сургууль төгсөгчдийн холбооны ерөнхийлөгч (С.Бат-Эрдэнэ)-өөр гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2. Хууль, журмын хүрээнд С.Бат-Эрдэнэтэй гэрээ байгуулж, шат дараалсан арга хэмжээг хамтран зохион байгуулж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

3. Гэрээний төлбөрийн 16,000,000 (арван зургаан сая) төгрөгийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010900